



ХУУЛЬЧИЙН ҮРГЭЛЖИЛСЭН СУРГАЛТЫН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ХОРОО /2023-2025/

Хуульчийн үргэлжилсэн сургалтын асуудал эрхэлсэн хороо нь Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1.3-д “хуульчийн үргэлжилсэн болон албан бус сургалтыг зохион байгуулах, багц цагийг тооцох”, Монголын Хуульчдын холбооны зөвлөлийн 2014 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн хурлын 27 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Хуульчийн үргэлжилсэн сургалт зохион байгуулах, багц цаг тооцох журамд заасан бүрэн эрхийн дагуу үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллаж байна.

Сургалтын хорооны бүрэлдэхүүн нь 2023 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн хурлаар хорооны гишүүдийг шинэчлэн баталсан ба УЕПГ-ын дэргэдэх Сургалт, Судалгааны хүрээлэнгийн прокурор, доктор, дэд профессор Б.Өнөрмаа-г хорооны даргаар сонгон 2023-2025 онд дараах бүрэлдэхүүнтэй ажиллаа.

№	Овог	Нэр	Албан Тушаал
1	Бямбажав	Өнөрмаа	Прокурор /хорооны дарга /
2	Багашар	Азбаяр	Шүүгч
3	Дашравдан	Халиуна	Шүүгч
4	Гочоо	Банзрагч	Шүүгч
5	Цээпил	Насанбат	Прокурор
6	Цоодол	Батболд	Прокурор
7	Өлзий	Эрдэнэ-Очир	Өмгөөлөгч
8	Цээпил	Азбаяр	Өмгөөлөгч
9	Гадинбуу	Наранбаатар	Өмгөөлөгч
10	Солоон	Болормаа	Хуульч
11	Ганчулуун	Оюунболд	Хуульч
12	Володя	Оюумаа	Хуульч
13	Лхагвасүрэн	Банзрагч	Хуульч



Сургалтын хороо 2023-2025 онуудад Монголын Хуульчдын холбооны гишүүн хуульчдын Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулиар хүлээсэн үүрэг болох хуульчийн үргэлжилсэн сургалтад хамрагдаж, багц цаг хангах үүргийн биелэлтийг хангуулах, хуульчдын мэдлэг, мэргэшлийн түвшин, ур чадварыг хууль эрх зүйн шинэчлэл, хэрэгцээ шаардлагад нийцсэн сургалтын хөтөлбөрөөр үргэлжилсэн сургалт зохион байгуулах үндсэн зорилгын хүрээнд дараах ажлуудыг хийсэн байна.

Нэг. Видео хичээлийн сургалтын хөтөлбөр боловсруулсан

Видео хичээлийн санг баяжуулах ажлыг эхлүүлэн Ханнс зайдел сантай хамтран “Үндсэн лекц ” цуврал видеог бэлтгэж сайтын цахим сургалт цэсэд байршуулсан.



ҮНДСЭН ЛЕКЦ: ЭРХ ЗҮЙГ ГҮЙВУУЛАХ БҮЮУ ХУУЛИЙГ ГАЖУУДУУЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ, ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙ ДЭХ ЗОХИЦУУЛАЛТ

Үндсэн лекцийг туршлагатай сургагч багш нар залуу сургагч багш нартай хамтран заасан бөгөөд сургалтын арга зүй шинэлэг, сургалтын чанар, үр өгөөж ач холбогдол бүхий хуульчийн сургалтын шинэлэг арга барилыг нэвтрүүлсэн сургалт юм.

Мөн хуульчдын онолын мэдлэг, хууль хэрэглээний чадварыг олон улсын түвшинд хүргэх, Үндсэн хууль, Эрүүгийн эрх зүй, Иргэний эрх зүй, Захиргааны эрх зүйн салбарт хууль хэрэглээний нэгдмэл байдлыг бий болгох зорилготой хичээл юм.



Хоёр: Цахим болон вебинар /зүүм/ сургалт

Хуульчийн үргэлжилсэн сургалтыг танхим, вебинар /зүүм/ болон танхим цахим хосолсон хэлбэрээр зохион байгуулахаас гадна шинэ сайт ашиглалтад орсонтой холбоотойгоор вебинар сургалт цэсээр дамжуулан Монголын Хуульчдын холбооны сайтад байрлах видео хичээлээр багц цаг тооцуулах боломжийг хуульчдад олгосон.

Холбооны сайтад 20 видео нийт 15,5 багц цагийн сургалтыг байршуулсан.



№	Хичээлийн нэр	Кредит
1	Үндсэн лекц-1	1
2	Үндсэн лекц-2	1
3	Үндсэн лекц-3	1
4	Үндсэн лекц 4	1
5	Үндсэн лекц 5	1
6	Үндсэн лекц 6	1
7	Бизнесийн хэлэлцээр хийх арга зүй	2
8	Хуульчийн мэтгэлцэх үр чадвар	1,5
9	Хуульчийн мэргэжлийн ёс зүй	0,5
10	Үл хөдлөх хөрөнгийн барьцааны эрх	0,5
11	Зохиогчийн эрхийн цахим орчин дахь хамгаалалт	0,5
12	Ажил гүйцэтгэх гэрээ	0,5
13	Хувьцаа худалдах, худалдан авах гэрээний нийтлэг зохицуулалт, практик	0,5
14	Компаний засаглал	0,5
15	Гэмт хэргийн хохирол, хор уршиг	0,5
16	Татварын хуулийн хэрэглээ болон хяналт шалгалт	0,5
17	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоо	0,5
18	Цахим гэмт хэрэг	0,5
19	Хуульчийн харилцаа хандлага	0,5
20	Төрийн албаны тухай хууль/Шинэчилсэн найруулга/	0,5



Гурав: Бусад байгууллагатай хамтарсан сургалт

- Улсын Дээд Шүүх;
- Улсын Ерөнхий прокурорын газар;
- Монголын Өмгөөлөгчдийн холбоо;
- Монголын Нотариатчдын танхим;
- Татварын Ерөнхий газартай хамтарсан “2022 оны татварын тайлан ба ХАОАТ, НӨАТ-ыг тайлагнах нь” сэдэвт сургалт;
- Авлигатай тэмцэх газрын албан хаагчдын сургалт;
- “Олон улсын Арилжааны арбитр”-ын сертификат олгох сургалт;
- Шүүхийн сахилгын хорооны сургалт;
- Хуулийн төсөл боловсруулагч бэлтгэх сургалт;
- Менторшип хөтөлбөрийн менти нарын сургалт;
- Үнэт цаасны зах зээлд үйлчилгээ үзүүлэх хуульчдад эрх олгох сургалт;
- Татварын мэргэшсэн хуульч бэлтгэх сургалт;
- Нийслэл, дүүргийн прокурорын газрын прокуроруудад зориулсан сургалт;
- Цагдаагийн Ерөнхий газрын хуульч албан хаагчдад зориулсан сургалт;
- Легал академи сургалтын төв;
- Олон улсын байгууллагууд.

Орон нутгийн сургалт

Аймаг орон нутгийн хуульчийн үргэлжилсэн сургалтыг бүсчлэн болон аймаг тус бүрт зохион байгуулахаас гадна цахим хэлбэрээр зохион байгуулсан.

ОНЦЛОХ СУРГАЛТУУДААС ДУРЬДВАЛ:

1. Сургагч багш чадавхжуулах сургалт.

Монголын Хуульчдын холбоо, Азийн сан хамтран Хуульчдын Холбооны Хуульчийн үргэлжилсэн сургалтын сургагч багш нарын хичээл заах арга, хэлбэрийг сайжруулах, туршлага, санал солилцох зорилгоор “Сургагч багш чадавхжуулах” нэг өдрийн сургалтыг зохион байгуулсан.

Сургалтыг “Суралцагчдыг идэвхжүүлэх зарим аргууд”, “Сургалтын слайд оновчтой бэлдэх аргачлал”, “Сургалт үр дүнтэй зохион байгуулах арга, туршлага”, “Багийн сэтгэл зүй ба харилцааны менежмент”, “Сургалт үр дүнтэй зохион байгуулах арга, туршлага- Хууль зүйн мэргэжлийн хичээлийн жишээн дээр” болон “Сургалтын жишиг хөтөлбөр боловсруулахад анхаарах зүйл” сэдвээр зохион байгуулсан ба Хуульчдын холбооны Сургалтын хорооны гишүүд, Хуульчдын холбооны сургагч багш нар, Азийн сангийн төлөөллөөс бүрдсэн нийт 50 сургагч багш хамрагдсан.



2. “Олон улсын Арилжааны арбитр”-ын сертификат олгох сургалт

Хуульчдын холбооны хүсэлтээр АНУ-ын Худалдааны яамны дэргэдэх Арилжааны эрх зүйн хөгжлийн хөтөлбөр (Commercial Law Development Program)-ийн дэмжлэгтэйгээр “Олон улсын Арилжааны арбитр”-ын сертификат олгох сургалт зохион байгуулсан.

АНУ-ын Худалдааны яамны дэргэдэх Арилжааны эрх зүйн хөгжлийн хөтөлбөр (Commercial Law Development Program) нь хөгжиж буй улс орны бизнесийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бөгөөд тус хөтөлбөр хэрэгжиж буй орны хуульч, судлаач, төрийн албан хаагчдад зориулан арилжааны эрх зүйн чиглэлээр сургалт явуулах, бусад оронд хэрэгжсэн сайн жишгийг танилцуулах, нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх зэрэг хууль зүйн техник туслалцаа үзүүлдэг.

Сургалтыг Сингапур, Япон Улсад үйл ажиллагаа явуулдаг Shearman & Sterling, DLA Piper олон улсын хуулийн фирмийн хуульчид Эммануэл Жакоми, Тонм Андрототис, Артис Страпенис нар явуулсан.



МОНГОЛЫН
ХУУЛЬЧДЫН
ХОЛБОО



CLDP
COMMERCIAL LAW DEVELOPMENT
PROGRAM

“ОЛОН УЛСЫН АРИЛЖААНЫ АРБИТРЫН СУРГАЛТ”



EMMANUEL JACOMY
“Shearman & Sterling” олон улсын
хуулийн фирмийн гишүүн

- Олон улсын бизнес, эдийн засгийн их сургуулийн (EQUIS) туслах профессор, Бээжингийн Цинхуа их сургуулийн эцэс профессор
- Эммануэль нь Олон Улсын Баруун холбооны Арбитрын асуудал хариуцаж хөрөө болон актын хэсгийг үндсэн ажилладаг
- Хятадын Олон Улсын Худалдааг Дэмжих Зөвлөл (CCPIT) болон Бээжингийн төмөр замын хэрэгсэл (BRT) хамтран байгуулсан Магадан нийгэмлэгийн олон улсын хэрэгсэлчдийн (CCPIT) шинэчлэлийн зөвлөлийн гишүүн



TONY ANDRIOTIS
“DLA Piper” олон улсын хуулийн
фирмийн гишүүн

- DLA Piper-ийн Токио дахь салбарын олон улсын арбитрын багийг удирддаг
- Олон улсын арбитрын төмөр замын төв, агууламрууд, Японы төмөр замын хамтанд тусламж үзүүлж байсан туршлагатай
- Азийн олон улсын арбитрын төв, Солонгосын арилжааны арбитрын зөвлөл, Шанхайн олон улсын арбитрын зөв, Японы арилжааны арбитрын нийгэмлэгт арбитрчар ажилладаг



ARTIS STRAUPENIEKS
“Shearman & Sterling” олон улсын
хуулийн фирмийн хуульч

- Сингапур дахь Shearman & Sterling-ийн олон улсын арбитрын бүтэцт ажилладаг
- ICC, SIAC, UNCITRAL, HKIAC зэрэг олон улсын арбитрын нэгэн дүрмийн дагуу өөрсдөө арбитрын ажиллагаанд ажилласан туршлагатай



3. ЛГБТ төвтэй хамтарсан сургалт

Хуульчдад ЛГБТИК+ эрхийн талаарх мэдлэг, ойлголтыг сайжруулах, эрх зүйн бүх салбарт хүний эрхийн мэдрэмжтэй хандлагыг төлөвшүүлэх зорилгоор Сургалтын хорооны дарга Б.Өнөрмаа сургалтын хөтөлбөр магадлан итгэмжлүүлж “сургалтыг



ЛГБТ төвтэй хамтран зохион байгуулсан бөгөөд тус сургалтад 200 гаруй өмгөөлөгч, 35 шинэ хуульч хамрагдан уг сургалтыг видео хэлбэрт оруулан Шүүхийн сургалтын нэгдсэн системд байршуулаад байна.



“ЛГБТИК+ ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИД ӨМГӨӨЛЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ НЬ” СЭДЭВТ СУРГАЛТ БОЛНО

Сургалтаар дамжуулан ЛГБТИК+ эрхийн талаарх мэдлэг, ойлголтыг сайжруулах, эрх зүйн бүх салбарт хүний эрхийн мэдрэмжтэй өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх арга зүйг төлөвшүүлэх зорилгоор Хуульчдын холбоо ЛГБТ төвтэй хамтран “ЛГБТИК+ үйлчлүүлэгчид өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх нь” сэдэвт нэг өдрийн сургалтыг зохион байгуулах гэж байна.

Хэзээ: 2023.05.17, 2023.05.18-ны өдрийн аль нэгэнд сонгон суух боломжтой
Сургалтын хамрах хүрээ: Нэг өдрийн хичээлд 18-20 хуульч хамрагдана

4. Хуулийн төсөл боловсруулагч бэлтгэх сургалт

Улсын Их Хурлын Тамгын газар, Швейцарын хөгжлийн агентлагийн “Монгол Улсад парламентын ардчиллыг бэхжүүлэх нь” дэд төсөл хамтран суралцагчдын хууль зүйн техникийн суурь мэдлэгийг бататгах, хуулийн төсөл боловсруулах арга зүй, ур чадварыг нэмэгдүүлэх, мэргэшүүлэх зорилготой “Хуулийн төсөл боловсруулагчийн сургалт”-ыг зохион байгуулсан.

Сургалтад УИХ-н Тамгын газрын алба хаагчид, холбогдох яамдын мэргэжилтнүүд болон Эдийн засаг хөгжлийн яамны хуульч албан хаагчид хамрагдсан.





Монголын Хуульчдын холбооноос Азийн сантай хамтран Менторшип хөтөлбөрийг 3 жил хамтран хэрэгжүүлсэн. Тус хөтөлбөр нь менти нарын хууль, эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх, ажлын арга барил болон харилцаа хандлагыг өөрчлөх, танилын хүрээг нэмэх зорилготой сургалт зохион байгуулсан.

Хуульчдын холбоо 2024 онд Менторшип хөтөлбөрийг бие даан хэрэгжүүлж тус хөтөлбөрт 10 ментор, 30 менти хамрагдсан бөгөөд хөтөлбөрийн зөвлөхөөр сургалтын Хорооны дарга Б.Өнөрмаа ажиллаж тус хөтөлбөрийг прокурорын байгууллагад 2 дах жилдээ амжилттай хэрэгжүүлж Цагдаагийн Ерөнхий газарт тус хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр бэлтгэл ажлыг хангаад байна.



МОНГОЛЫН ХУУЛЬДЭЛН ХОЛБООНЫ МЕНТОРШИП ХӨТӨЛБӨР-2021





Г.ОЮУНБОЛД
Монголын Криминалистикагийн хоолбооны сургалт, судалгааг уриалсан зохиогч

"Менторшип" өгснэ нь эхэр хийжн халамж, баша, сүргэн хүмүүхүүлэгчлэйн үүргийн онг нахтай хоолбооны холлослуун харилцааг хэлнэ. Ментор нь ментийн өмрийн өмжнэ турлиор, эрхлэ халамж халамжнуу хүмүүхлэж, эхэр сүргэн, эхэр зүгнэ нь менторлуудын ментийн өмжнэ харилцаа, халамжн өмжнэдрээ эхлэ халамжнуу байх халамжн дэвхлэж нь тусгаар эрхлэвч хүмүүхлэж халамж.

Боловсрол

- Цэцэрлэгийн өмжнэдр, Хууль зүйн боловсрол, мангир
- Хүүхүүлэгчлэйн үүргийн Их сүргүүл, боловсрол

Ажилласан турлиор

- 2002-2004 онд Холд өмжнэдр менторлэйн халамжн эхлэвч бэлтгэл
- 2004-2007 онд Монгол зүйн цэцэрлэгийн цэцэрлэгийн халамжн ментор
- 2007-2012 онд Хууль зүйн үүргийн хуульчлэйн эхлэвч халамжн өмжнэдр
- 2009-2011 онд Нутагт халамжн харилцааг бэлтгэл
- 2012, 2016 онд Логоос халамжн Их сүргүүл зүйн цэцэрлэгийн өмжнэдр, сүргүүлэйн өмжнэдр халамж
- 2012-2016 онд Хууль зүйн өмжнэдр халамжн, халамжн эхлэвч
- 2016-2020 онд УЕГ-нь Сүргүүлэйн тивд эхлэвч халамжн цэцэрлэж
- 2020-11 сараас Монголын Криминалистикагийн хоолбооны сургалт, судалгааг эхлэвч халамжн

[illegible]

7. Үнэт цаасны зах зээлд үйлчилгээ үзүүлэх хуульчдад эрх олгох сургалт

Монголбанкны дэргэдэх Санхүүгийн зохицуулах хороотой хамтын ажиллагааг үргэлжлүүлж гэрээ байгуулахаар хэлэлцэж, Үнэт цаасны зах зээлд үйлчилгээ үзүүлэх хуульчдад эрх олгох сургалтыг зохион байгууллаа.

Тус сургалт нь үнэт цаасны зах зээлд хууль зүйн мэргэжлийн, чанартай зөвлөгөө өгөх хуульчдыг бэлтгэх, мэргэжлийн ур чадварыг сайжруулах зорилготой, хуульчдад сертификат олгох сургалт юм.



8. Татварын мэргэшсэн хуульч бэлтгэх сургалт

Монголын Хуульчдын холбоо, Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэг хамтран татварын мэргэшсэн хуульчийн сургалтыг зохион байгуулж сургалтад хамрагдсан хуульчдад “Татварын мэргэшсэн хуульч” батламж гардуулсан.





Сургалтын хороо 2023 – 2025 онуудад хуульчийн үргэлжилсэн сургалтыг нийт 84 удаа буюу танхимын сургалт 56, танхим бус /цахим/-аар 28 сургалт зохион байгуулсан.

Дээрх онуудад сургалтад нийт 6488 хуульч хамрагдсанаас танхимын сургалтад 5572 хуульч, цахимаар 795 хуульч, орон нутагт 121 хуульч хамрагдсан байна.

Дөрөв: Журамд нэмэлт өөрчлөлт оруулах ажлын хүрээнд

Монголын Хуульчдын холбооны Зөвлөлийн 2014 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн хурлын тогтоолоор батлагдсан Хуульчийн үргэлжилсэн сургалт зохион байгуулах, багц цаг тооцох журмыг бүхэлд нь өөрчлөн найруулж

- 2023 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн хурлын 07 дугаар тогтоол,
- 2024 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн 08 дугаар тогтоол,
- 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн хурлын тогтоолоор тус тус шинэчлэн өөрчлөн найруулж Монголын Хуульчдын холбооны Зөвлөлөөр батлуулсан.

Онцлог заалтуудаас дурьдвал

Монголын Хуульчдын Холбоонд 70-аас дээш настай 114 хуульч, хөгжлийн бэрхшээлтэй хөдөлмөрийн чадвараа алдсан 20 хуульч бүртгэлтэй байна.

Хуульчдын холбоо нь хуульчдын мэргэжлийн өөрөө удирдах ёсны байгууллага болохын хувьд гишүүн хуульчдынхаа эрх ашгийг хамгаалах, тэдэнд шаардлагатай дэмжлэг туслалцаа үзүүлэх үүрэгтэй тул “Хуульчийн үргэлжилсэн сургалт зохион байгуулах, багц цаг тооцох журам”-д дээрх хуульчдын эрх зүйн байдлыг дээрдүүлсэн агуулга бүхий заалт оруулах нь зүйтэй гэж үзэн Сургалтын Хорооноос санаачлан сургалтын журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай төсөл боловсруулж дараах журмын заалтыг батлуулсан.

Хуульчийн үргэлжилсэн сургалт зохион байгуулах, багц цаг тооцох журмын 7.2 дугаар зүйлд

4. 70-аас дээш настай хуульчийг сургалтын багц цаг хангах үүргээс чөлөөлнө.

5. Хөгжлийн бэрхшээлтэй хуульчийг холбогдох нотлох баримтыг үндэслэн тухайн жилд хангах багц цагийн сургалтаас 50 хувь хөнгөлнө.”

Мөн Монголын Хуульчдын холбооны зөвлөлийн 2023 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн хурлын 07 дугаар тогтоолоор Албан бус сургалтын журмыг санаачлан 2 бүлэг 8 зүйл бүхий журмыг батлуулан хэрэгжүүлж байна. “Албан бус сургалт” гэж Холбооны сургалтын хороогоор зөвшөөрөгдсөн, Холбоотой байгуулсан хамтын ажиллагааны санамж бичгийг үндэслэн захиалгат, эсхүл Холбооны санаачилсан, санал болгосон, бие дааж, эсхүл бусадтай хамтарч төлбөртэй, эсхүл төлбөргүйгээр зохион байгуулах сургалтыг хэлнэ.



Тус сургалтын хүрээнд дараах байгууллагуудад сургалт зохион байгуулж хамтран ажиллаа. .

- Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар
- Эдийн засаг хөгжлийн яам
- ЛГБТ төв
- Легал академи сургалтын төв
- УИХ-ын Тамгын газрын дэргэдэх Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэн

Тав: Хөтөлбөр магадлан итгэмжлэх ажлын хүрээнд

Журмын 4.5 дугаар зүйлийн 1.6-д заасны дагуу Хороо сургагч багш, хөтөлбөрийн жагсаалтыг 2 жил тутамд шинэчлэнэ гэж заасны дагуу сургалтын хөтөлбөрт мониторинг хийсэн. 2025 оны байдлаар магадлан итгэмжлэгдсэн 86 хөтөлбөр, 93 сургагч багш бүртгэлтэй байна.

Зургаа: Бусад ажлын хүрээнд

Монголын Хуульчдын холбооны 10 жилийн ойг тохиолдуулан Хуульчийн үргэлжилсэн сургалтын асуудал эрхэлсэн хорооны санаачилгаар сургалтын багц цаг хангаагүй, үүргийн зөрчилтэй хуульчдад хөнгөлөлт үзүүлэхээр Зөвлөлийн 2024 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн хурлаар шийдвэрлүүлсэн.

Тус хөнгөлөлтийг хэрэгжүүлэхдээ Монголын Хуульчдын холбоо байгуулагдсанаас хойш буюу 2014 оны нэгдүгээр сарын 01-ний өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл хугацаанд хуульчийн үргэлжилсэн сургалтын багц цаг хангаагүй хуульчдад дутуу багц цагийн 50 хувьтай дүйцэхүйц цахим хичээлийг сонгон судалснаар бүрэн хангасанд тооцохоор болсон.

Хөнгөлөлт үзүүлэх санаачлагыг гаргахдаа сургалтын хороо нь дараах тодорхой тоо, баримт судалгааг хийсэн.

Тухайлбал: Хичнээн хуульч багц цаг хангах үүрэгтэй, хүчингүй, түдгэлзүүлсэн, чөлөөлөгдсөн хуульчдын мэдээллийг нягтлан гаргасан.



МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ ХУУЛЬЧИЙН ҮРГЭЛЖИЛСЭН СУРГАЛТЫН БАГЦ ЦАГИЙГ ШҮҮСЭН ТООН МЭДЭЭ



2014-2022 он хооронд хүртэл **36** кредит цагийг хангах ёстой.

50% буюу 18 кредитийн үлдэгдэлтэй **1651** хуульч байна.



18-20 кредит дутуу 214



20-30 кредит дутуу 973



30-аас дээш кредит дутуу 462

1651 хуульчаас:

МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ ХУУЛЬЧИЙН ҮРГЭЛЖИЛСЭН СУРГАЛТЫН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ХОРООНЫ ТОГТООЛ

2024 оны 03 дугаар сарын 21-ний өдөр Дугаар №01 Улаанбаатар хот

Монголын Хуульчдын холбооны Чиг үүргийн хороодын үйл ажиллагаа явуулах нийтлэг журмын 4.2 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг удирдлага болгон Хуульчийн үргэлжилсэн сургалтын асуудал эрхэлсэн хорооны хурлаас ТОГТООХ нь:

Монголын Хуульчдын Холбооны 10 жилийн ойт тохиолдуулан сургалтын багц цаг хангаагүй үүргийн зөрчилтэй хуульчдад хөнгөлөлт үзүүлэх тухай:

- 2023 он хүртэлх хугацаанд хуульчийн үргэлжилсэн сургалтын багц цаг хангаагүй үүргийн зөрчилтэй нэгт хуульчид дутуу кредитийн 50 хувьтай дүйцэхүйц видео хичээлийг сонгон үзсэнээр 100 хуви хангагдсанд тооцсугай.
- Тус хөнгөлөлтийг 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд олгосугай.
- Заасан хугацаанд үүргийн биелэлтээ хангаагүй хуульчдыг Хуульчийн үргэлжилсэн сургалт зохион байгуулах, багц цаг тооцох журмын 7.3 дугаар зүйлийн 3-т зааснаар "...хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хүчингүйд тооцуулахаар Ерөнхийлөгчид шилжүүлэх"-ийг мэдэгдсугай.
- Мэдээлэл хүргүүлэх, зохион байгуулах, шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг хорооны мэргэжилтэн /З.Алтанзул, Б.Цэрэнлхам, Б.Батмандай / нарт даалгасугай.

ХУУЛЬЧИЙН ҮРГЭЛЖИЛСЭН СУРГАЛТЫН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ХОРООНЫ ДАРГА
Р.НО Б.ӨНӨРМАА

МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ ЧИГ ҮҮРГИЙН ХОРОО

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Сүхбаатарын талбай-7
Монголын Хуульчдын холбооны байр
Вей: www.mglbar.mn, E-mail: info@mglbar.mn
Утас: 70110304, Факс: 70110304

2024.06.05 №: 11/11
Тайлбар: ХМ №:

Санал хүргүүлэх тухай


Хуульчийн үргэлжилсэн сургалтын асуудал эрхэлсэн хороо нь:
1. Хуульчийн үргэлжилсэн сургалтын багц цаг тооцох журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай санал.
2. 2023 он хүртэлх хугацаанд сургалтын багц цаг хангаагүй үүргийн зөрчилтэй хуульчдад хөнгөлөлт үзүүлэх тухай Хуульчийн үргэлжилсэн сургалтын асуудал эрхэлсэн хорооны 2024 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн хурлаас гарсан шийдвэрийг Холбооны зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх саналтай байх тул зөвлөлийг 2024 оны 06 дугаар сард багтаан хуралдуулах санал гаргаж байна.

Иймд саналыг хүлээн авч, шийдвэрлэж өгөхийг хүсье.

Жич: Сургалтын хорооны 2024 оны 03 дугаар сарын 21-ний №01 дүгээр тогтоолыг хавралтаар хүргүүлээ.
Мөн журамд орох нэмэлт өөрчлөлтийг Зөвлөл харуулсан мэргэжилтэнд файлаар илгээсэн болно.
Хавсралт: 1 хуудастай

ХУУЛЬЧИЙН ҮРГЭЛЖИЛСЭН СУРГАЛТЫН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ХОРООНЫ ДАРГА
Р.НО Б.ӨНӨРМАА

Үүний дагуу нийт 2200 гаруй хуульч хүсэлтээ ирүүлсэн бөгөөд хүсэлт ирүүлсэн хуульчдын багц цагийн тооцоог хуульч нэг бүрчлэн гаргаж хариу мессэж болон мэйлийг дараах байдлаар илгээсэн.



Хөнгөлөлтөд хамрагдах хуульчдын тоог дараах байдлаар тооцоолоход хамгийн багадаа 3948 хуульч байгааг Холбооны зөвлөлд танилцуулсан.

20-оос дээш багц цагийн үлдэгдэлтэй хуульчдын мэдээлэл /5 жил/

1. Шүүгч- 234
2. Прокурор – 11
3. Өмгөөлөгч- 689
4. Бусад хуульч- 688
5. Нотариатч- 25

Нийт: 1654 хуульч байна.

Хамгийн бага дүнгээр бодвол $10 \text{ кр} \times 65,000 \times 1654 = 1,075,100,000$

/нэг тэр бум далан таван сая нэг зуун мянга/



20-оос доош багц цагийн үлдэгдэлтэй хуульч- 2294

1. Шүүгч-127
2. Прокурор – 151
3. Өмгөөлөгч- 522
4. Бусад хуульч- 1441
5. Нотариатч- 53
6. Нийт: 2294 хуульч

Хамгийн бага дүнгээр бодвол $5 \text{ кр} \times 65,000 \times 2294 = 745,550,000$

/ долоон зуун дөчин таван сая таван зуун тавин мянга /

Үүргийн зөрчилтэй: Хамгийн багадаа 3948 хуульч



Хөнгөлөлтөд хамрагдах хугацааг хуульчдын хүсэлтээр 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл сунгасан бөгөөд энэ хугацаанд 2278 хуульч хамрагдаж сургалтын багц цагаа бүрэн хангасан байна. Үүнээс харахад хуульчдын 60 хувь нь үүргийн зөрчилгүй болсон байна.

6.1 “ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛ” СЭДЭВТ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА. /2024.02.28/

Монголын хуульчдын холбооноос “Эрүүгийн эрх зүйн шинэтгэл” сэдэвт хэлэлцүүлгийг 2024 оны 2 сарын 28-ний өдөр тэнхим, цахим хослуулан нийт 65 шүүгч, прокурор, өмгөөлөгчийг хамруулан зохион байгууллаа. Тус хэлэлцүүлэгт Монголын хуульчдын холбооны ерөнхийлөгч П.Одгэрэл оролцож, хэлэлцүүлгийг судлаач, доктор Б.Өнөрмаа чиглүүлэн, “Эрүүгийн хуулийн системчлэл” сэдвийг судлаач, доктор Т.Золбоо, “Эрүүгийн хуулийн хэрэглээ ба онол” сэдвийг УДШ-ийн Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн Ч.Хосбаяр, “Хүний эрхийн хязгаарлалт ба эрүүгийн хууль” сэдвийг ХҮЭК-ын гишүүн, доктор Б.Энхболд, “Эрүүгийн болон захиргааны хариуцлага /хуулийн уялдаа холбоо/” сэдвийг МХХ-ны Эрүүгийн эрх зүйн хорооны удирдах зөвлөлийн гишүүн, хуульч, өмгөөлөгч Ж.Батмөнх нар хэлэлцүүлж, оролцогчтой ярилцлаа.

МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБОО

"ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛ"

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Модератор:

Б.ӨНӨРМАА
 Хуулийн үргэлжлсэн сургалтын
 асуудал хэрэгсэл хорооны дарга,
 Доктор /Ph.D/

Панелист:

Ч.ХОСБАЯР
 Монгол Улсын Дээд
 Шүүхийн Эрүүгийн хэргийн
 танхимын тэргүүн

Б.ЭНХБОЛД
 ХҮЭК-ийн гишүүн,
 Доктор /Ph.D/

Т.ЗОЛБОО
 Судлаач, Доктор /Ph.D/

Ж.БАТМӨНХ
 Эрүүгийн эрх зүйн хорооны
 удирдах зөвлөлийн гишүүн,
 хуульч, өмгөөлөгч

Холбоо: УЕПГ-н дэргэдэх Сургалт, Судалганы хүрээлэнгийн хурлын танхим болон цахим /Zoom/ | Хэсэг: 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдөр /Лхагва гарал/ | Утас: 88863375

Хэлэлцүүлгийн зорилго нь Эрүүгийн эрх зүйн болон Хууль зүйн салбаруудын төлөөлөл болсон панелистуудаас бүрдсэн ба Эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааныг дэмжих, хууль батлах үйл ажиллагаанд мэргэжлийн дэмжлэг үзүүлэх, бодлогын судалгаа болон бодлогын нөлөөлөл хийх зэрэг хуулиар хамгаалсан үүргээ хэрэгжүүлэх хүрээнд салбарынхаа бодлогыг тодорхойлох юм.



6.2 МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБОО МОНГОЛ-СОЛОНГОСЫН ЭРХ ЗҮЙН ХҮРЭЭЛЭНТЭЙ ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ САНАМЖ БИЧИГ БАЙГУУЛЛАА /2024.03.15/

Монголын Хуульчдын холбооны Ерөнхийлөгч П.Одгэрэл, ОУ-ын Улаанбаатарын их сургуулийн Монгол-Солонгосын эрх зүйн хүрээлэнгийн захирал О.Амарсанаа нар хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурсан. Тус уулзалтад Хуульчийн үргэлжилсэн сургалтын асуудал эрхэлсэн хорооны дарга Б.Өнөрмаа оролцсон.



6.3 ЦАХИМЖИЛТ БА БАРЫН ХОЛБОО хэлэлцүүлэг

2024.03.25-ны өдөр зохион байгуулагдсан ба Хорооны гишүүн Г.Наранбаатар, Г.Оюунболд нар нь хороог төлөөлөн оролцлоо.



6.4 Монгол Улсад захиргааны хэргийн шүүх байгуулагдсаны 20 жилийн ойд зориулан зохион байгуулж буй “МОСК TRIAL-3ХШ 20 ЖИЛ” мэтгэлцээний тэмцээн /2024.04.12/

Сургалтын хорооны гишүүн, УДШ-ийн Захиргааны хэргийн танхимын шүүгч, Г.Банзрагч орж ажилласан.





6.5 "БРИДЖ II" ТӨСЛИЙН ОЛОН УЛСЫН ЗӨВЛӨХ ЮН ГАОНЫГ ХҮЛЭЭН АВЧ УУЛЗЛАА

Монголын Хуульчдын холбооны Ерөнхийлөгч П.Одгэрэл Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас хэрэгжүүлж буй "Бридж II" төслийн Олон Улсын зөвлөх Юн Гаоныг 2024 оны дөрөвдүгээр сарын 30-ны өдөр хүлээн авч уулзлаа. Уулзалтад Монголын Хуульчдын холбооны Сургалтын хорооны дарга, доктор Б.Өнөрмаа оролцлоо.



6.6 МОНГОЛ БА БНСУ-ЫН ЭРХ ЗҮЙН ТОГТОЛЦОО, ХАМТЫН АЖИЛЛАГАА” ОЛОН УЛСЫН СИМПОЗИУМД ИЛТГЭЛ ХЭЛЭЛЦҮҮЛЖ ОРОЛЦЛОО.

Монголын Хуульчдын холбоо нь Олон Улсын “Улаанбаатар” их сургуулийн Монгол-Солонгосын эрх зүйн хүрээлэнтэй байгуулсан хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд БНСУ-ын Төрийн өмчит хууль зүйн судалгааны хүрээлэн, Гёнги Өмгөөлөгчдийн холбоо, Ажү Их сургуулийн Хууль зүйн сургуулийн дэмжлэгтэйгээр “МОНГОЛ БА БНСУ-ЫН ЭРХ ЗҮЙН ТОГТОЛЦОО, ХАМТЫН АЖИЛЛАГАА” сэдэвт олон улсын симпозиумыг 2024 оны долдугаар сарын 02-ны өдөр зохион байгууллаа.

Тус симпозиумын нэгдүгээр хэсэг “Эрүүгийн хариуцлага” сэдвийн хүрээнд явагдсан бөгөөд Монголын Хуульчдын холбооны Хуульчийн үргэлжилсэн сургалтын асуудал эрхэлсэн хорооны дарга, доктор, дэд профессор Б.Өнөрмаа “Эрүүгийн хариуцлагын зорилго, төрөл, шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн онцлог” сэдвээр илтгэл хэлэлцүүлж оролцлоо.



Зохон байгуулагч:



Монголын
Хуульчдын
холбоо



ОУУБИС-ийн
Монгол-Солонгосын
эрх зүйн хүрээлэн



БНСУ-ын төрийн өмчит
Хууль зүйн судалгааны
хүрээлэн



БНСУ-ын Гэнги
Өмгөөлөгчдийн
холбоо



БНСУ-ын Ажү их
сургуулийн Хууль зүйн
сургууль



Монголын
Хуульчдын
холбоо



ОУУБИС-ийн
Монгол-Солонгосын
эрх зүйн хүрээлэн



БНСУ-ын төрийн өмчит
Хууль зүйн судалгааны
хүрээлэн



БНСУ-ын Гэнги
Өмгөөлөгчдийн
холбоо



БНСУ-ын Ажү их
сургуулийн Хууль зүйн
сургууль

ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГА



6.7 Монгол Улсын Их хурлын дарга Д.Амарбаясгалан Монголын Хуульчдын холбооны Ерөнхийлөгч П.Одгэрэлийг хүлээн авч уулзаж, хууль эрх зүйн орчны шинэчлэлийн талаар ярилцлаа. /2024.08.29/

Монгол Улсын Их хурлын дарга Д.Амарбаясгалан Монголын Хуульчдын холбооны Ерөнхийлөгч П.Одгэрэлийг хүлээн авч уулзаж, хууль эрх зүйн орчны шинэчлэлийн талаар ярилцсан ба тус уулзалтад Сургалтын хорооны гишүүн Г.Оюунболд оролцлоо.



6.8 ХӨДӨЛМӨРИЙН ХЭМ ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ОЛОН УЛСЫН СУРГАЛТАД ХАМРАГДЛАА

Европын холбооны дэмжлэгтэйгээр Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагаас хэрэгжүүлж буй “Зохистой хөдөлмөр ба худалдаа” төслийн хүрээнд 2024 оны 11 дүгээр сарын 4-8-ны өдрүүдэд Итали Улсын Турин хотноо зохион байгуулсан "Олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээ ба хариуцлагатай бизнес эрхлэлт" сэдэвтэй сургалтад Монголын Хуульчдын Холбоо, ГБХНХЯ, ХХААХҮЯ, Шүүхийн академи, Монголын Хөнгөн аж үйлдвэрлэлийн ҮЭ-ийн холбоо, Монголын Ноос ноолуурын холбооны төлөөллүүд оролцлоо.

Тус сургалтад Монголын Хуульчдын холбоог төлөөлөн Сургалтын хорооны гишүүн С.Болормаа оролцсон.

Сургалтад хамрагдсанаар Олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээг хэрэгжүүлэх, зохистой хөдөлмөр түүнд хамаарах ойлголтуудыг хэрхэн ойлгож хэрэгжүүлэх талаар салбарын хүрээнд хамтарч ажиллах юм.



6.9 АЗИЙН ПРО БОНО ЧУУЛГА УУЛЗАЛТАД СУРГАЛТЫН ХОРООНЫ ТӨЛӨӨЛӨЛ ИЛТГЭЛ ХЭЛЭЛЦҮҮЛЖ ОРОЛЦЛОО

Монголын Хуульчдын холбооноос Азийн 13 дахь удаагийн Про боно чуулга уулзалтыг Монгол Улсад зохион байгуулах эрхийг авч 2025 оны 10 дугаар сарын 01-07-ны өдрүүдэд зохион байгуулсан. Чуулга уулзалтад 30 гаруй орны 300 гаруй төлөөлөгч оролцсон.

Энэхүү чуулганд Сургалтын хорооны дарга, доктор, дэд профессор Б.Өнөрмаа, Сургалтын хорооны гишүүн, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Клиник сургалтын төвийн захирал, доктор, профессор С.Болормаа нар салбар хуралдаанд “Олон салбарын оролцоотой Пробоно: Өнгөрсөн, одоо, ирээдүй – Монголын туршлага” сэдвээр илтгэл хэлэлцүүлсэн.



